



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 16/02

Арвайхээр сум

“Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1.1.1 дэх заалт, “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн эдийн засаг-нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийг орон нутагт ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (А.Ишдорж)-д даалгасугай.

3. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх, Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж үр дүнд хүрч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

О. ПҮРЭВДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн
16/02 дугаар тогтоолын хавсралт



“НЭЭЛТТЭЙ ӨВӨРХАНГАЙ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус бодлогын баримт бичигт боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжил, ногоон хөгжил, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 6 багц асуудал туссан.

Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөгөөр салбарын яам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн авч хэрэгжүүлэх ажлын чиглэлүүд батлагдсан.

Иймд аймаг орон нутгийнхаа эдийн засаг-нийгмийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, аймгийн түүх, соёл, зан заншил, уламжлал, техник, технологи, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ололт амжилтыг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн суртачлах “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг холбогдох бодлогын баримт бичиг, судалгаанд үндэслэн боловсруулсан.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.1. “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох зорилтот хөтөлбөрүүд, орон нутгийн бодит нөөц бололцоо, аймгийн эдийн засгийн салбаруудыг кластер хэлбэрээр тооцоолон хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах бодлогод тулгуурлана;

2.1.2. Орон нутагт шилжин ирж ажиллаж, амьдрах, бизнесийн үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсэж болзошгүй хүндрэл бэрхшээлийг бодитоор тооцоолж мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээхийг чухалчилна;

2.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон

мэргэжлийн холбоодын оролцоог хангаж, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Өвөрхангай аймгийн эдийн засаг-нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, иргэдийг орон нутагт ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх замаар аймгийн хүн амыг арваас доошгүй хувиар нэмэгдүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1. Бизнесийн таатай орчин бүрдүүлж, хөрөнгө оруулалт татах, хүний нөөцийн хангамжийг нэмэгдүүлнэ.

4.2. Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

4.3. Томоохон төсөл, хөтөлбөрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.4. "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлого"-ыг олон нийтэд сурталчилж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Бизнесийн таатай орчин бүрдүүлж, хөрөнгө оруулалт татах, боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлнэ.

5.1.1. Аймгийн эдийн засгийн хөгжлийн баримт бичиг, загварчлал боловсруулан, хэрэгжилтийг зохион байгуулж, сумдын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.

5.1.2. Аж ахуйн нэгжүүд, түүний дотор гарааны компаниудыг хөгжүүлэх зорилгоор бизнесийн зөвлөгөө, мэдээллээр тогтмол хангаж, орон нутагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх;

5.1.3. "Нээлттэй Өвөрхангай" хөрөнгө оруулалтын форум, чуулганыг нийслэл болон орон нутагт зохион байгуулж хөрөнгө оруулалт татах;

5.1.4. Томоохон судалгаа, инновацын мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

5.1.5. Орон нутгийн боловсон хүчнийг чадавхжуулах чиглэлээр мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллах;

5.1.6. Орон нутагт хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах;

5.1.7. Зарим их, дээд сургууль, мэргэжлийн сургалтын байгууллагууд, тэдгээрийн салбар сургуулиудыг орон нутагт байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх;

5.1.8. Орон нутагт дотоодын томоохон үйлдвэрүүдийн салбарыг нээх санал санаачилга гаргасан аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хамтран ажиллах;

5.1.9. Төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, тэдгээртэй холбоотой хууль, дүрэм, журмыг боловсронгуй болгох санал боловсруулж эрх бүхий байгууллагад уламжлах;

5.1.10. Зарим орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд болон ашиглалтгүй байгаа орон нутгийн өмчийн барилга, объектуудыг хувийн хэвшилд шилжүүлэх арга хэмжээ авах;

5.1.11. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Гучин-Ус, Арвайхээр, Хархорин, Есөнзүйл, Сант сумдын төвийг "Бүсийн хөгжлийн төв" болгон дэмжин хөгжүүлэх.

5.2. Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

5.2.1. Аймгийн хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх;

5.2.2. Усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;

5.2.3. Эрчимжсэн аж ахуйг дэмжиж, малжуулах төсөл хэрэгжүүлэх.

5.2.4. Аймгийн "Аялал жуулчлалын брэндиг"-ийн судалгаа гаргаж, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх; (*Элсний болон өвлийн аялал жуулчлал, сарлаг, адуу, тэмээний баярыг тогтмол зохион байгуулах*)

5.2.5. Аймаг, сумдын түвшинд газар олголтын үйл ажиллагааг ил тод болгож аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, газар тариалан, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгох газрыг хүртээмжтэй төлөвлөж хэрэгжүүлэх;

5.2.6. Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, стандартыг мөрдүүлэх;

5.2.7. Арвайхээр хотод төмс, хүнсний ногооны автоматжуулсан зоорь байгуулах;

5.2.8. Дайвар бүтээгдэхүүний болон сүү, цагаан идээ боловсруулах, сав, баглаа боодол, хэвлэлийн үйлдвэр байгуулах;

5.2.9. Хоршооны хөгжлийг дэмжиж, сумдад түүхий эдийн хөргүүртэй зоорь байгуулах, түүхий эд бэлтгэлийн анхан шатны тордолт бүхий цэгүүд байгуулах;

5.2.10. Жимс, жимсгэнэ боловсруулах, малын тэжээлийн, бордоо, яс, тос, борц, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлэх.

5.3. Томоохон төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

- 5.3.1. “Орхон-Онги” эко төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- 5.3.2. Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн 40МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц байгуулах;
- 5.3.3. Хархорин суманд олон улсын 4С зэрэглэл бүхий гүний гаальтай агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолбор олон улсын нисэх буудлын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;
- 5.3.4. Арвайхээр-Шивээ хүрэн чиглэлийн 500 км авто замыг барьж эхлүүлэх;
- 5.3.5. Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн босоо тэнхлэгийн авто замыг барьж эхлүүлэх;
- 5.3.6. Арвайхээр-Хужирт чиглэлийн 43.3 км автозамыг барьж ашиглалтад оруулах;
- 5.3.7. Үүрэн холбооны сүлжээний дахин дамжуулах станцын тоог нэмэгдүүлж, сүлжээний хамрах хүрээг нэмэгдүүлэх;
- 5.3.8. Мандалговь-Арвайхээр чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 кВ-ын дэд станц байгуулах;
- 5.3.9. БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “МОН-14” төслийн хүрээнд Арвайхээр хотод 30МВт-ын дулааны станц ашиглалтад оруулна. Тус дулааны станцыг ашиглалтад оруулахад нэн шаардлагатай 2 дугаар контурын шугам сүлжээ, 10/0.4 кВ-ын 2х2000 кВА чадлын дэд станц, 10 кВ-ын кабель шугам, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл угсралтын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх;
- 5.3.10. Арвайхээр хотод тээвэр логистикийн төв байгуулж, баруун бүсийн аймгуудад бараа материал борлуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- 5.3.11. Арвайхээр хотод хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах “Үйлдвэр технологийн парк” байгуулах;
- 5.3.12. Сумын төвүүдэд инженерийн шугам сүлжээ байгуулах, өргөтгөх замаар үйлдвэр, үйлчилгээ хөгжих суурь нөхцөлийг бий болгох;
- 5.3.13. Зарим сумдад орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 5.3.14. Орон нутагт сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр шинээр байгуулах ажлыг дэмжих;
- 5.3.15. Уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, цемент, боржин, хүрмэн чулуу боловсруулах үйлдвэрүүд байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж хэрэгжүүлэх;
- 5.3.16. Орон нутагт нисэх буудлуудын үйл ажиллагааг сэргээж, онцгой нөхцөлд сумдад нислэг үйлдэх боломжийг бүрдүүлэх;

5.3.17. Аялал жуулчлалын бааз, отоглох цэг, оператор компаниудыг дэмжин, аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах замаар жуулчдын тоог нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх.

5.4. “Хот хөдөөгийн сэргэлтийн бодлого”-ыг олон нийтэд сурталчилж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

5.4.1. “Нээлттэй Өвөрхангай” нэгдсэн арга хэмжээг нийслэлд зохион байгуулах;

5.4.2. “Нээлттэй Өвөрхангай” мэдээллийг нэг дороос авах цахим тогтолцоо (Нээлттэй Өвөрхангай аппликэйшн)-г бий болгож, үйлчилгээний нэгдсэн төв болон нийслэлд мэдээлэл түгээх суваг бий болгох;

5.4.3. Их, дээд сургуулиудад суралцаж байгаа Өвөрхангай аймгийн оюутан, залуучуудыг орон нутагтаа ирж ажиллаж, амьдрахад уриалах уулзалтыг жил бүр зохион байгуулах.

5.4.4. Аймаг, сумын нутгийн зөвлөлийн уулзалт нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, аймаг, сумдад шилжин суурьшигчдад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;

5.4.5. Орон нутагт үйл ажиллагаа явуулахаар шилжин ирэх аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд, холбогдох хууль тогтоомж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар сургалт зохион байгуулах, гарын авлага, постер, видео бэлтгэн олон нийтийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан иргэдэд түгээх;

5.4.6. “Нээлттэй Өвөрхангай” хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах ажлыг төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, аймгийн онцлог, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, төрийн үйлчилгээ, иргэдэд чиглэсэн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх;

5.4.7. Иргэний нийгмийн байгууллагуудтай “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн бодлогын хүрээнд хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, тэднээр дамжуулан иргэдэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ;

5.4.8. Олон нийтийн сүлжээнд давамгайлан оролцогч нар (инфлүүзер)-тай гэрээ байгуулж, орон нутагт шилжин суурьших давуу тал, боломжийг олон нийтэд сурталчлах;

5.4.9. Өвөрхангай аймгийн нэгдсэн брэнд бүтээх цогц сургалт дадлагажуулалт, брэнд хөгжүүлэх туршилт, судалгаа, уралдаан зохион байгуулах;

5.4.10. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын сул ажлын байрны судалгаа, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.4.11. Залуу боловсон хүчнийг орон нутагт ажиллуулах зорилгоор “Нутгаа хөгжүүлье” залуучуудын уулзалт арга хэмжээг зохион байгуулах;

6. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүүжилт

6.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар бүрдүүлнэ.

6.2. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах байгууллага, албан тушаалтнууд нэгдсэн зохион байгуулалтаар ажиллана.

Үүнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
2. Аймгийн Засаг даргын Тамгын газар
3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсөвт байгууллагууд
4. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар
5. Салбар, мэргэжлийн холбоод
6. Аймаг, сумдын Нутгийн зөвлөлүүд
7. Иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд

6.3. Аймгаас байгуулагдсан дэд ажлын хэсэг нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт тавьж, холбогдох байгууллагуудад чиглэл өгч ажиллана.

6.5. Зохион байгуулах үүрэг бүхий байгууллагууд нь ажлын явцын мэдээллийг хагас, бүтэн жилээр нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.

6.6. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг жил тутам аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэнэ.

---oOo---